



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/38

Төмөрбулаг сум

Г Тээврийн хэрэгслийн үзлэг тооллого
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Зам тээврийн сайдын 2013 оны 232 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2024 оны А/160 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоо, бүртгэлийг зохион байгуулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ч.Энхбаяр-засаг даргын орлогч
Гишүүдэд: Ц.Баярцэнгэл- хэсгийн төлөөлөгч
О.Оюунбаатар - цагдаа
Ц.Доржготов-1-р багийн засаг дарга
Н.Бямбачулуун-2-р багийн засаг дарга
Л.Батсайхан-3-р багийн засаг дарга
Д.Эрдэнэжаргал-4-р багийн засаг дарга
Ш.Нацагдорж -5-р багийн засаг дарга
Нарийн бичгийн дарга: Б.Ёндонсамбуу-татвар хураагч

2. Сум, багт байгаа автомашин, чиргүүл, трактор, өөрөө явагч хэрэгсэл мотоциклийн бүртгэл судалгаа гаргаж бэлтгэл ажлыг ханган техникийн үзлэгт тээврийн хэрэгслийг бүрэн хамруулж ажиллахыг Ажлын хэсэг /Ч.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д даалгасугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ